

ХЯТАД УЛСЫН ИРЭЭДҮЙН ТАЛААРХ ТААМАГЛАЛ

А.Батцэцг¹

Бид энэ зууныг Хятадын зуун гэж нэрлээд байгаа. Хүмүүсийн хэлж байгаатай адил Хятад улс үнэхээр их гүрэн болох зорьсондоо хүрч чадах уу гэдэг асуудал, мөн өнөөгийн төлөв байдал, цаашдын хандлага нь мэдээж сонирхол татам зүйл гэж бодож байна.

Хятад хүмүүс өөрийнхөө улсыг дэлхийн их гүрэн болж чадахгүй гэж дүгнэдэг. Харин гадныхан үнэхээр хурдтай өсч байгаа, их гүрэн болно гэж үздэг.

Бодит байдал дээр дээрх хоёр талын байр суурь ямар байгааг харьцуулан авч үзэх нь зөв юм. Хятад нь үйлдвэрийн олон төрөл зүйл бараагаар өнөөдөр дэлхийн хамгийн том зах зээл болоод байгаа бөгөөд 2015 он гэхэд бараг бүх бараагаар ийм болно. Өнөөдөр л гэхэд Хятад ган, бордоо, унадаг дугуй, цаг, хөргөгч, телефон сүлжээний холбогч систем, зурагт радио болон бусад барааны хамгийн том үйлдвэрлэгч болоод байна.

Хятадын 1,27 тэрбум хүний 1/3 нь 20 хүртэлх наасны залуучууд бөгөөд зөвхөн 7 % нь л 65, түүнээс дээш наасны хүмүүс юм. Үүгээр юу хэлэх гээд байна вэ гэхээр Хятад улсын хүн амын ихэнх хувийг хөдөлмөрийн наасны хүмүүс эзэлдэг нь энэ улсыг хөгжих бас нэгэн шалтгаан мөн гэсэн уг.

Хятад нь аж үйлдвэржүүлэлт, хотжуулалт, зах зээлийн эдийн засаг руу хийх шилжилт гэсэн гурван хувьсгалыг нэгэн зэрэг хийж байна. Күнзийн Гуанши –эдийн засаг хийгээд коммунист төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу хийх шилжилт нь 1997 онд хоёр дахь шийдвэрлэх үе шатандаа оржээ. Бүх хүнд ашгаа өгсөн Дэнийн шинэчлэл цаашдаа Зяны “нулимстай шинэчлэл” рүү хөтөлсөн бөгөөд шинэчлэл либералчлалын үйлсээс үүдсэн ажилгүйдэл, тэгш бус байдал, авилга, хээл хаахууль, нутаг орноосоо дайжин явах, гэмт хэрэг зэрэг нийгмийн шилжилтийн хүндрэл бэрхшээл зайлшгүй байв. Хорин нэгдүгээр зууны эхээр Хятад улс дахин сэргэх замынхаа хамгийн эрсдэлтэй хэсэгт ороод буй.

Алс ирээдүй тийш хараа сунгахын өмнө өнөөгийн байдал дээр тогтох, Хятад улсын өмнө тулгарч буй асуудлуудыг авч үзэхэд бүх асуудлын үр үндэс болсон хүн амын хэт өсөлтийн асуудал байна. Хятад улс өргөн уудам нутаг дэвсгэртэй хэдий ч нутгийнх нь ихээхэн хэсгийг уул нуруу, говь цөл эзэлдэг. Хүн ам нь дорнын тэгш газар, өмнийн далайн эрэг хавийн бус нутаг, Сычуань сав газар шавааралдан суух билээ. 2000 онд Хятад 1,27 тэрбум хүнтэй байв. Айл өрхийг нэг л хүүхэдтэй байх бодлого явуулсан хэдий ч хүн ам нь 0,9 хувиар өссөн байна. Тэгээд дечин жилийн дараа л хүн амын тоо 1,5 тэрбумд хүрэх үед өсөлт тогтвортин.

Хүн амын өсөлтийн шууд үр дагавар болох тэсрэх аюул бол ажилгүйдэл болно.

2000-2010 оны хооронд Хятадын хөдөлмөрийн чадвартай хүн ам хөдөлмөрийн нас хэтрэгсдийг хасч бодвол цэврээр 70 саяар нэмэгдэнэ. Тиймээс хөдөлмөрийн зах зээл жил тутам 7 сая гаруй нэмэгдэл ажлын байр бий болгох ёстой бөгөөд таван жилийн дараа энэ тоо нийт Германы ажлын байрын тоотой тэнцэх болно. Үүний дээр улсын секторт цомхогтол ургэлжлэх нөхцөлд жилд таван сая шинэ ажлын байрны хэрэгцээ гарна. Гэвч сорилт үүгээр

¹ МУИС, ОУХС-ийн багш, докторант

дуусахгүй. Тариачны нэг өрхөд дөнгөж 0,55 га талбай ногдож буйгаас болж ажил эрхлэлт дэндүү өчүүхэн учир хөдөө аж ахуйг 2010 оныг хүртэлх хугацаанд 75 орчим сая хүн орхин явах болно. 1984-1996 оны завсрлын үе шинээр байгуулагдаж байсан хөдөөгийн аж үйлдвэр, үйлчилгээний газрууд ажлын байр ихээр нэмэгдүүлж байв. Гэвч 1996 онд энэхүү хөгжил эцэс болж 1997-2000 оны хооронд хөдөөгийн аж үйлдвэрт ажил эрхлэлт эрс багасжээ. 2000-2010 он хүртэлх арван жилд хөдөөгийн аж үйлдвэр аж ахуйн газрууд хөдөө аж ахуйгаас шилжин ирсэн 20 сая хүнийг хүлээж авах ч 50 сая хүн хөдөөд ажилгүй үлдэнэ гэсэн үг. Маогийн үед гарсан өрхийн бүртгэлийн хууль нь хүмүүсийг төрсөн газартай нь хадаж өгчээ. Энэ хуулиар хөдөөгийн хүн ам хөдөө нутагтаа түгжигдмэл хадаастай байдаг. Гэвч өرنөн хөгжиж байсан хөдөөгийн аж үйлдвэр оргил үедээ ч гэсэн аж ахуйд ажилтай болж чадаагүй бүх хүний ажлаар хангаж чаддаггүй байсан. Тиймээс ажил хайгчид хууль дүрмийг үл хайхран хотууд руу шилжиж байв. 90-ээд оны дундаас эхэлсэн шилжилт хөдөлгөөний энэ урсгал улам өргөжин тэлэв. Хөдөөд бүртгэлтэй 150-200 сая хүн хууль бусаар аль эсвэл хугацаатай оршин суух эрхтэйгээр хотуудад сууж байв. Тэд аргагүйн эрхэнд барилга, үйлдвэр, гуанз зэрэгт өөрөөөр хэлбэл хотынхны тоож хийхээргүй ажлыг эрхэлж, ямар ч нийгмийн хамгаалалгүй, үр хүүхэд нь боловсролгүй, байнга хөөгдөх вий гэсэн айдастай амьдарч байна.

Хотуудад ажилгүйдэл 20 хувьд хүрсэн гэж бие даасан ажиглагчид үзэж байна.² Улам өссөөр байгаа тэрбум хүн амаа ажилтай байлгахын тулд Хятад юу хийх ёстай вэ? Харамсалтай нь Хятад улс алдагдалтай эдийн засгаас хэт үйлдвэрлэлт шилжин орсноос үүдэн эдийн засгийн ажлын байр шинээр бий болгох чадвар нь ихээхэн багасаад байна. Эдийн засаг 8 хувиар өслөө ч гэсэн энэ нь шинээр бий болж буй ажиллах хүчиний цэвэр өсөлтийг л шингээхээс биш одоо байгаа ажилгүйчүүдийг яаж ч чадахгүй. Даяаршил өнөөдөр аж үйлдвэрээс бүтээмжээ нэмэгдүүлэхийг шаардаж буй билээ.

Хүн амын хэт өсөлттэй нягт холбоотой хоёр дахь үндсэн асуудал бол байгаль орчны эвдрэл сүйрэл юм. Хятадын хотууд утаанд багтарч байна. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хөрс эвдэрч, цөлжиж байна. Шар мөрний ус олон сараар тасарч байлаа. Усны дутагдал бол хамгийн хурц асуудал болоод буй. “Усны хэрэгцээний 2/3 гүний усаар хангадаг Бээжинд 1999 онд усны түвшин нь 3,5 м-ээр дошилжээ.”³ Ус, газар, агаар нь эдийн засгийн цаашдын өсөлтийг хангахад хүрэлцэхгүй болох аюул заналхийлж байна.

Далайн эргийн муж, нутгийн гүний мужуудын хоорондын хөгжлийн тэгш бус байдал, хот хөдөөгийн хоорондын хөгжлийн ялгаа зэрэг нь дээр дурдсан байгалийн сүйрлээс дутахааргүй асуудал болоод байгаа билээ. Өнөөдөр нийт хүн амтай харьцуулбал цөөн тооны саятнууд байгаа. Мөн 300 сая орчим гишүүнтэй дээд давхарга байх бөгөөд диско бүжиг хийгээд хүнд рок тоглодог кафенуудад алтан үеийн залуучууд бүжиглэж нарgidag жишигээтэй. Нөгөөтэйгүүр Хятад 1978 оноос үнэмлэхүй ядуурлыг бараг бүрэн арилгаж чадсан гэдгийг хэлэх хэрэгтэй. Албан ёсны статистикийн мэдээгээр “хөдөөгийн хүн амын цэвэр орлого 1985 онд хотынхны орлогын 54% тай тэнцэж байсан бол 2000 онд 36%-д хүртлээ буурчээ.”⁴ Энэ нь тариачдын хорслыг улам бүр төрүүлж буй.

Хөгжлийн их хурдац хүмүүст шинэ үнэт зүйлсийг хуучныхын оронд суулгаж өгөхгүйгээр амьдралын уламжлалт хэлбэр, үнэт зүйлсийн талаарх ойлголтоос салгаж байна. Олон хүн мөнгөнд шунаж үхэн хатан хөөцөлдөхөөс өөр аргагүй болжээ. Намаас энэхүү орон зайг эх оронч үзэл, Хятадын күнзийн үеийн аугаа түүхээр бахархах үзлээр дүүргэхийг оролдож байна. Оюун ухааны хоосрол бол ёс суртахууны хоосролыг дагуулдаг. Хотуудад гэмт хэрэг газар авч байна. Үүнд хотынхон ажил эрэн хэсүүчлэн явж буй хөдөөнийхнийг буруутгаж байгаа билээ.

Улс төрийн тогтвортой байдалд хамгийн аюултай зүйл бол нам, захираганы боловсон хүчиний дотор авилгын асуудал гарч буй явдал юм. Энэ нь хуримтлагдаж бутгшсан бусад асуудлаар дүүрэн торхтой дарийг асааж мэдэх юм. Хятадын эзэнт гүрний өнө удаан жилийн

² www.chinabroadcast.cn

³ www.mongol.cri.cn

⁴ zuich.nomin.net

бараагаар ийм болно. Mash олон үндэстэн дамнасан томоохон компаниуд Хятад дахь салбартаа илүү анхаарч, төвөө шилжүүлцгээж байгаа билээ. “Тошиба Японд буй зурагтын үйлдвэрээ хаагаад өөрийн зах зээлд зориулсан барааны үйлдвэрлэлээ Хятад руу шилжүүлсэн, минолта аппаратныхаа үйлдвэрийг Япондоо зогсоогоод Шанхай дахь үйлдвэрийнхээ бүтээгдэхүүнээр орлуулах болсон”⁷ гэх мэт маш олон баримтуудыг тоочиж болно. Үйлдвэрлэлийг Хятад руу шилжүүлэх энэ асар их урсгал Зүүн Өмнөд Ази, Өмнөд Азид таагүй тусч байна.

Хятад ДХБ-д элссэнээр гадаадын хөрөнгө оруулалтын нөхцөл хурдтай сайжирч байгаа бөгөөд энэ нь даян дэлхийн өнцөг булан бүрээс үйлдвэрлэл Хятад руу шилжих явдлыг улам хурдаасгаж байна. Түүнчлэн Хятад нь дэлхийн мэдээллийн технологийн үйлдвэр болж буй бөгөөд энд компьютерын бүрдүүлэгч эд ангийн ихээхэн хэсгийг үйлдвэрлэж буй.

Эцэст нь дүгнээд хэлэхэд хүн амын дийлэнх хувь хөдөлмөрийн насны zaluuучууд, мөн хятад бараа, үйлчилгээ дэлхийн өнцөг булан бүрт тархсан байдал, 2015 он хүртэл хөгжлийн цаашдын хэтийн төлвийг харгалзан үзээд Хятад үнэхээр дэлхийн их гүрэн болох зорилгодоо амжилттай хүрч чадаж байна гэдэг дүгнэлтэд хүрлээ. Гэвч хэт хурдацтай энэ хөгжлийг хятадууд өөрсдөө ч хүчээр сааруулахыг оролдож байгаа билээ. Шаарыг хэт үлээхээр хагардагтай адил хөгжил цэцэглэлтийн оргилд хүрсэн ямарваа улс үндэстэн заавал мөхөн сүйрдэг болох олон гашуун үнэнг Хятад улс давтахыг хүсээгүй бололтой.

Aшигласан материал

1. www.chinabroadcast.cn
2. www.mongol.cri.cn
3. www.zuuch.nomin.net
4. www.chinadaily.cn
5. www.asiafinest.com
6. www.wikipedia.org
7. www.google.com

⁷ www.wikipedia.mn